



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/70

Бат-Өлзий сум

Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.21, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.4.1, 9.4.5 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Бүх нийтийн хог цэвэрлэгээг 2023 оны 04 дүгээр сарын 26-наас 2023 оны 04 дүгээр сарын 29-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажилд албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн орчин, айл өрхийн хашаа, гудамж, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлүүлэн, хогийг нэгдсэн цэгт ангилан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг албан байгууллагуудын дарга, эрхлэгч (Н.Бат-Эрдэнэ, Б.Ууганчимэг, Д.Энх-Амгалан, Н.Батжаргал, Ж.Тогоохүү, Г.Баттулга, Ж.Булганзаяа), багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт даалгасугай.

4. Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчид, банкны албан хаагчид, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг иргэдийг нийтийн эзэмшлийн газар, голын голдирогын ойролцоо хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажилд бүртгэн, цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан (Н.Долгормаа, Б.Орбиш), (багийн Засаг дарга нар, байгууллагын дарга, эрхлэгч) нарт даалгасугай.


5. Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдрүүдэд олон нийтийг хамарсан уралдаан, тэмцээн зохион байгуулахыг хориглосугай.

6. Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулахтай холбогдуулан 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийж ажиллахыг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч (Н.Батжаргал), 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Ж.Тогоохүү), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Б.Ууганчимэг) нарт үүрэг болгосугай.

7. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг тухай бүрд авч нэгдсэн удирдлагаар ханган, үр дүнгийн тайланг 2023 оны 05 дугаар сарын 03-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Янжиндулам) нарт даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



622301147

Сумын Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 25-ны өдрийн  
А/70... дугаар захирамжийн хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Нарийн бичгийн дарга: Б.Янжиндулам (Байгаль орчны асуудал хариуцсан  
мэргэжилтэн)

Гишүүд: Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга,  
Цагдаагийн хошууч)

Б.Ууганчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн  
захирал)

Ж.Булганзаяа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Г.Баттулга (Соёлын төвийн даргын ажлыг дүр орлон  
гүйцэтгэгч)

Д.Очирхуяг (Ойн ангийн дарга)

Н.Батжаргал (1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч)

Ж.Тогоохүү (2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

И.Маралмаа (Газрын даамал)

Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)

Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Ш.Бумандолгор (Ойн инженер)

А.Мягмардагва (Ойн инженер)

Ц.Амгалан (Ойн техникч)

Х.Чулуунбат (Тусгай хамгаалалттай газрын Байгаль  
хамгаалагч)

Ш.Баасансүрэн (Тусгай хамгаалалттай газрын  
Байгаль хамгаалагч)

М.Мөнхдалай (Тусгай хамгаалалттай газрын  
Байгаль хамгаалагч)

--oOo--